

switchasia



Funded by the
European Union



CZECH REPUBLIC
DEVELOPMENT COOPERATION



**БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ
БОЛОН БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ
ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ
ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД
ХИЙСЭН СУДАЛГАА**

УЛААНБААТАР ХОТ
2019 ОН

Тайланг бичсэн:

Г.Шоовдор /Монголын Барилгачдын Нэгдсэн Холбооны Гүйцэтгэх захирал, Монгол Улсын Зөвлөх инженер/

Энэхүү тайланг Каритас Чех Репаблик болон хамтрагч байгууллагуудын хэрэгжүүлж буй “Монгол Улсын барилгын салбарын нөөцийн үр ашигтай байдал, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих” төслийн хүрээнд боловсруулан гаргав. Тайланд орсон агуулга нь Европын Холбооны байр суурийг илэрхийлээгүй болно.

ТАЙЛАН, СУДАЛГАА ДҮГНЭЛТИЙН ТОЙМ

“Каритас Чех Репаблик” ТББ-аас Европын Холбоо, Чехийн Хөгжлийн Агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Монгол Улсын барилгын салбарын нөөцийн үр ашигтай байдал, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих” (2016-2020) төслийн хүрээнд Монгол Улс дахь барилгын хог хаягдлын менежмент болон барилгын хог хаягдлыг дахин боловсруулахтай холбоотой хууль, эрх зүйн орчныг судалж, шинжлэн зөвлөмж Тайланг боловсруулан гаргах ажлын хүрээнд доорхи ажлыг хийж гүйцэтгэлээ.

Хог хаягдлын тухай хуулийн (2017) 4.1.37 –д заасны дагуу Барилгын хог хаягдал гэж нэрлэсэн барилгын суурь бэлтгэх, барилга барих, засварлах, буулгах, болон авто зам барих, засварлахад үүсэх хог хаягдал, явган хүний зам талбай, ногоон байгууламж, тохижилт, инженерийн шугам сүлжээ тавих, засварлах, солих үед үүсэх хог хаягдал болон барилгын материалын худалдаа, үйлдвэрлэлээс гарах хог хаягдлыг хэлнэ. Барилгын хог хаягдал, эх үүсвэр, хуримтлал өнөөгийн байдал болон энэ чиглэлээр Улаанбаатар хотын хэмжээнд хийгдсэн судалгаа цаашид хэрэгжүүлэх зарим арга хэмжээний талаар дүгнэлт гаргах ажлын хүрээнд дараах хүмүүстэй уулзаж, ярилцлага хийн санал солилцсон ба үүнд:

- Барилга, хот байгуулалтын яамны (БХБЯ) Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэргэжилтийн газрын дарга Л. Билэгжаргал
- БХБЯ-ны Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэргэжилтийн газрын ахлах мэргэжилтэн Г. Цэрмаа
- Барилгын хөгжлийн төвийн (БХТ) Норм нормативын хэлтсийн дарга Д. Алтанхуяг
- БХТ-ийн Норм, нормативын хэлтсийн ахлах мэргэжилтэн Н. Батжилмаа
- “И Жи Эс Стандарт консалтинг” ХХК-ны захирал Т. Энхтуул
- “И Жи Эс Стандарт консалтинг” ХХК-ны зөвлөх П. Наранчимэг
- Монголын Хог Хаягдлыг Дахин Боловсруулах Үндэсний Холбооны (МХХДБҮХ) –ны удирдах зөвлөлийн гишүүн Д. Батжаргал
- “Ган ганжир” ХХК-ны захирал МУ-ын зөвлөх инженер Ц.Ганбат
- “Баян бүст” ХХК-ны захирал Б. Анхбаяр
- Монголын Барилгын Материал Үйлдвэрлэгчдийн Холбооны (МБМҮХ)-ны менежер, МУ-ын зөвлөх инженер Г. Оч

2. Барилгын салбарын хог хаягдлын менежмент болон барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйл ажиллагаатай холбоотой хууль, дүрэм, тогтоол шийдвэр, журам, тушаал, норм, стандартыг цуглуулан холбогдох баримт

бичгүүдэд тусгагдсан зорилтууд, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх судалгааг хийсэн болно.

3. Барилгын хог хаягдлын чиглэлийн хууль, стандарт, дүрэм журмын хэрэгжилт хангалтгүй байгаагийн шалтгаанд холбогдох дүгнэлт хийв.

4. Монгол Улсын хэмжээнд болон барилгын салбарт мөрдөх хууль эрх зүйн баримт бичгүүд шинэчлэгдсэн байна.

Тухайлбал: Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 5 дугаар сарын 12-ны Хог хаягдлын тухай хууль (шинэчилсэн найруулга) мөн 2016-2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, 2014 оын 9 дүгээр сарын 18-ны өдрийн 298 дугаар тогтоолоор батлагдсан “Хог Хаягдлын Менежментийг Сайжруулах Үндэсний хөтөлбөр”, МУ-ын Засгийн Газрын 2015 оны 6 дугаар сарын 29-ний “Хог хаягдлыг бууруулах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах үйл ажиллагаа эрхэлсэн болон хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг сурталчилж, урамшуулал олгох журам, 2018 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн 116 дугаар тогтоолоор батлагдсан “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам”, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас (БОАЖС) 2018 онд А/443 дүгээр тушаалаар батлагдсан “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага” –журам зэрэг хууль тогтоомжид холбогдсон судалгааг гаргасан болно.

5. Барилгын салбарын онцлог, хууль эрх зүйн орчин нөхцөл, өнөөгийн хэрэгжилтийн байдалд судалгаа дүгнэлт хийж цаашдын үйл ажиллагааны талаар зөвлөмж боловсрууллаа.

6. Монгол Улсад мөрдөх “Барилгын хог хаягдлын MNS (Mongolian National Standard) үндэсний стандарт”-тай болох зорилгоор ОХУ-ын болон бусад орны стандартуудыг Монголын нөхцөлд тохируулан нэвтрүүлж, нутагшуулж болох стандарт, норм дүрмүүдийг хавсаргав. (Хавсралт 1)

7. Тайланг гаргахдаа КЧР болон Нидерланд Улсын Дельфтийн Технологийн Их Сургуулийн 2017 онд боловсруулан гаргасан “Барилгын хог хаягдлын менежментийн суурь судалгаа” болон “Монгол Улсад барилгын хог хаягдлыг дахин боловсруулах боломжийн судалгаа”-тай тус тус танилцсан.

8. Судалгаа хийж дүгнэлт зөвлөмж гаргахад ашигласан эх сурвалжуудыг хавсралтад тусгав. (Хавсралт 2)

**ЭНД БАРИЛГЫН
НУРААЛТЫН
АЖИЛ ЯВАГДАЖ
БАЙНА.**



**ДЭЭРЭС ЮМ УНАН
БОГЗОШУЙ ОРЧИН**



**АЖУЛТАЙ
ОРЧИН**

1. Барилгын хог хаягдлын менежмент болон барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйл ажиллагаатай холбогдсон хууль, эрх зүйн орчны өнөөгийн нөхцөл байдалд хийсэн судалгаа

Монгол Улсын хэмжээнд барилгын хог хаягдлын нэгдсэн менежментийн тогтолцоо төлөвшөөгүй, барилгын хатуу хог хаягдлыг ил задгай хамаагүй хаядаг, тогтмол хугацаанд татан зайлуулдаггүй, зөвхөн газарт дарж булах аргаар устгадаг, аюултай хог хаягдлыг устгах дүрэм, журам тэр болгон байхгүйгээс ихээхэн хэмжээний хогны хуримтлал нийслэл, аймаг хотын хэмжээнд бий болсон байна.

Барилгын салбар хөгжиж шинэ технологи нэвтрэх үйл явц маш эрчимтэй явагдаж байгаагийн үр дүнд 10 жилийн өмнөхтэй харьцуулбал барилга барих явцад гардаг барилгын хог хаягдлын төлөв, төрөл эрс өөрчлөгдсөн байна.

Тухайлбал:

- А. Бүрэн цутгамал технологиор барилга байгууламжийн үндсэн каракас хийцийг барих арга барил түлхүү нэвтрэх болсноор мөн бетон зуурмагийн болон бетон хийцийн төвлөрсөн үйлдвэрүүдэд бэлтгэж, зөөврийн хутгагч машинаар зөөж, тусгай бетон насосоор цутгаж байгаа зэргээс болоод барилгын талбайд элс, хайрга бетон эдлэлийн хог хаягдал гарах хэмжээ багассан.
- Б. Барилгын төсөв, нормчлол тооцооны аргачлал цахимжиж программчлагдан тооцоо сайжирсны үр дүнд барилгын материалаас илүүдэл хог хаягдал гарах нь мөн багассан.

2. Барилгын салбарын хог хаягдлын эх үүсвэрийн байдал

2.1 Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд хийгдсэн судалгааны тойм

Нэгдүгээрт :


Улаанбаатар хотын агаар, хөрсний бохирдолтыг багасгах зорилгоор гэр хорооллыг бүсчлэн хөгжүүлэн орон сууцжуулах хөтөлбөр төсөл эрчимтэй хэрэгжиж байна. Энэхүү үйл явцтай уялдан гэр хороололд орон сууцны барилга байгууламж барих явцад:

- А. Амины орон сууц, хашаа, байгууламж, зам талбай хөрс зэргийг буулгах, шинэчлэх ажлуудыг гүйцэтгэх явцад бетон, тоосго, блок, мод, бусад материал, бохирдсон хөрс, шороо, элс хайрга зэрэг барилгын хог хаягдал ихээхэн хэмжээгээр гарч байна.

- Б. Улаанбаатар хотод бүтээн байгуулалтын ажил эрчимтэй явагдаж байгаа өнөө үед барилгын сууриас гарах хаягдал шорооны хэмжээ улам нэмэгдэж гарсан шорооны 25-35% нь эргэн булалт, өндөршилт, ногоон байгууламж зэрэгт ашиглагдаж, үлдсэн 65-75% нь дурын газарт хаягдаж байна.

Улаанбаатар хотыг 2020-2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд (УИХ-ын 2013 оны 2 дугаар сарын 08-ны 23 дугаар тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөөний тодотгол 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг) гэр хорооллыг байршил, инженерийн дэд бүтцийн сүлжээнд холбогдох байдал ба орон сууцны төрөл гэсэн үндсэн нөхцөлөөс хамаарч гэр хорооллын дахин төлөвлөлтийг тодорхой үе шаттайгаар төвийн, дунд, захын гэсэн гурван бүсэд хувааж төлөвлөсний дагуу орон сууцны хорооллууд баригдана.

- Б. Улаанбаатар хотын 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага



Эх сурвалж: УИХ-ын 2013 оны 2 дугаар сарын 08-ны 23 дугаар тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөөний тодотгол 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг



Зургийг Н. Үүрийнцолмон /Төслийн менежер/

бэх, төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гаргаж паспортжуулах олон нийтийн зориулалттай ашиглалтын шаардлага хангахгүй 61 барилгын жагсаалт, үйл ажиллагааны төсвийг батлан төлөвлөгөө гарган ажиллаж байна.

- 2018 онд Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас хийсэн судалгаагаар Улаанбаатар хотын хэмжээнд нийт 234 орон сууцны барилгыг ашиглах боломжгүй гэсэн дүгнэлт гарсан байна.
- Европын сэргээн босголт, хөгжлийн банкны зээлээр Морингийн давааны төвлөрсөн хогийн цэгт барилгын хог хаягдал буталж, ангилах үйлдвэр, энгийн хог хаягдал дарж булах ландфиллын байгууламж барих төслийг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын (НЗДТГ) Бодлого төлөвлөлтийн хэлтсээс Засгийн газрын хуралдаанд Төслийг хэрэгжүүлэх зээлийн асуудлыг оруулж хэлэлцүүлсэн. Засгийн газраас уг асуудлыг УИХ-аар хэлэлцүүлсэн ба Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын (НИТХ) Тэргүүлэгчдийн 2018 оны 4 дүгээр сарын 10-ны 50 дугаар тогтоолоор Нийслэлийн Засаг даргыг Европын сэргээн босголт, хөгжлийн банктэй гэрээ байгуулах эрхийг олгосноор НЗД-ын орлогч П. Баярхүү гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулсан. НЗДТГ-аас төслийг хэрэгжүүлэх зөвлөх сонгох Үнэлгээний хороо нь Нийслэлийн Засаг даргын 2018 оны 5 дугаар сарын 09-ний А/407 дугаар захирамжаар байгуулагдан ажиллаж байна.
- Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай 30га газрын кадастрын зургийг 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулсан.
- Төслийг хэрэгжүүлэх 30 га талбайд барилгын хог хаягдлыг ландфиллын технологээр дарж булан, бутлах байгууламжийг барьж, 2021 онд ашиглалтанд оруулахаар төлөвлөж байна.
- Мөн Цагаан давааны төвлөрсөн хогийн цэгт Эко парк төслийн хүрээнд барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийг 2019 онд багтаан ашиглалтанд оруулахаар төлөвлөсөн байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

2.1.Барилгын салбарын стандартчиллын өнөөгийн байдал

Барилгын салбарын хэмжээнд мөрдөх хууль эрх зүйн баримт бичгүүд шинэчлэгдэн батлагдаж түүнтэй уялдан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө, бусад хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдтэй холбогдуулан гарсан барилгын салбарын стандартчиллын байдлыг доорх хүснэгтэд 2.1.1 ба 2.1.2-т тус тус харуулав.

Барилгын салбарт батлагдсан стандартуудын төрөл

Хүснэгт 2.1.1

Стандартын үзүүлэлтүүд (он)	2017	2018
Барилгын стандартын тоо	11	12
Шинээр боловсруулсан	11	12
Үүнээс: Үндэсний болгосон ISO стандартын тоо	2	-
Үндэсний буюу MNS стандартын тоо	2	6
Үндэсний болгосон ГОСТ стандартын тоо	-	-
Үндэсний болгосон EN стандартын тоо	1	5
Үндэсний болгосон ASTM стандартын тоо	6	-
Үндэсний болгосон бусад стандартын тоо	-	1 (BS)
Олон улсын түвшинд хүрсэн стандартын тоо	82% (11-ээс 9 нь олон улсын болон гадаад орны дэвшилтэт стандарт)	50% (12-оос 6 нь олон улсын болон гадаад орны дэвшилтэт стандарт)
Дахин хянасан стандартын тоо	-	-
Нэмэлт өөрчлөлт оруулсан стандартын тоо	-	-
Хүчингүй болгосон	-	-

Хүснэгт 2.1.2

2017, 2018 онуудад батлагдсан стандартууд:

Стандартын үзүүлэлт/он	2017	2018
Барилгын салбарын стандарт	<ol style="list-style-type: none"> 1. MNS EN 206:2017 2. MNS ISO 11485-1:2017 3. MNS ISO 11485-1:2017 4. MNS 0864:2017 5. MNS ASTM D 2488:2017 6. MNS ASTM D 2166:2017 7. MNS 6686:2017 8. MNS ASTM D 4767:2017 9. MNS ASTM D 2850:2017 10. MNS ASTM C 127:2017 11. MNS ASTM D 128:2017 	<ol style="list-style-type: none"> 1. MNS 6712:2018 2. MNS 6713:2018 3. MNS EN 14364:2018 4. MNA 5072:2018 5. MNS BS 952-1:2018 6. MNS EN 1288-1:2018 7. MNS EN 572-1:2018 8. MNS EN 572-4:2018 9. MNS EN 572-9:2018 10. MNS 11. MNS 12. MNS 4947:2018

Хүснэгт 2.1.3





Зургийг П. Сэргэлэн /ШУТИС, БАС-ийн Ахлах багш/

Барилгын норм ба дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт

Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр “Барилгын норм ба дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 09 тоот тушаал гарсан. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Барилгын норм ба дүрэм батлах тухай” Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2012 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 181 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Барилгын төсөв зохиох дүрэм” /БНбаД81-95-12/-ийн Хавсралт №1-ийн Загвар №2-т тооцоо хийх тайлбарын “*Үе шатны ажлын материалын хог хаягдлыг бохир жингийн дүнгээс барилгын дүрэмд заасан хог хаягдлын нормоор 6 хувиар тооцно*” гэсэн хэсгийг хүчингүй болгож доорх өөрчлөлтийг оруулсан байна.

Үүнд:

“Барилга төсөв зохиох дүрэм” /БНБД 81-95-12/-д оруулсан нэмэлт, өөрчлөлт

Тухайлбал: Барилгын 1м² талбайд ногдох барилгын дахин хэрэглэгдэхгүй хог хаягдлын нормативыг доорх хүснэгтийн дагуу тооцно.

Д/д	Барилгын төрөл	1м ² талбайд ногдох хог хаягдлын норматив /тонн/
1	Барилга байгууламж шинээр барих	0.013
2	Барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэх	0.015
3	Барилга байгууламжийг засварлах, тоноглох	0.017
4	Барилга байгууламжийг буулгах	0.024

А. Барилгын 1м² хог хаягдлын жин 1300 кг байна.

Б. Барилгын хог хаягдлын ажлын тоо хэмжээг тодорхойлохдоо гадна ханын ирмэгээр тооцсон барилгын нийт талбайн хэмжээг 1м² талбайд ногдох барилгын дахин хэрэглэгдэхгүй хог хаягдлын нормативаар үржүүлнэ.

В. Барилгын хог хаягдлын ажиллах хүчний зардлыг Барилга, хот байгуулалтын сайдын 2005 оны 80 дугаар тушаалаар баталсан “Барилгын засварын ажлын төсвийн суурь норм” /БНБД 81-59-05/-оор тооцно.

Г. Барилга, байгууламжийг буулгах үйл ажиллагааны дүрэм БД20-101-20

Д. “Үйлдвэрийн газрын хортой хог хаягдлыг булшилж аюулгүй болгох бүс газар, төлөвлөлтийн шаардлага” БНБД - ийг боловсруулж байна.

Хог хаягдлын менежмент болон барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйл ажиллагаатай холбоотой хууль дүрэм, журам, стандарт

1. Барилгын тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2016 оны 2 дугаар сарын 05
2. Хог хаягдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2017 оны 5 дугаар сарын 12
3. Хог хаягдлын тухай хууль-ийн 6.1.5-д заасны дагуу “Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр” (2014 оны 9 дүгээр сарын 18)
4. 2018 онд “Барилгын доторх хог хаягдлын менежмент-Ашиглалтын дүрэм MNS BS5906:2018 үндэсний стандарт”
5. Хот байгуулалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2008 оны 5 сар
6. Стандартчилал, техникийн зориулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2018 оны 7 дугаар сар
7. МУ-ын ЗГ-ын 2016 оны 121 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”
8. Засгийн газрын 2009 оны 157 дугаар тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлтийн гамшгийн эрсдлийг бууруулах үндэсний хөтөлбөр”
9. УИХ-ын 2016 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай”
10. МУ-ын ЗГ-ын 2016 оны 282 дугаар тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө”
11. Барилга хот байгуулалтын яамны сайдын 2018 оны 1 дүгээр сарын 16–ны 09 тоот тушаал “Барилгын норм, дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”
12. 2015 оны 6 дугаар сарын 26-ны “Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль”
13. БХБЯ-ны сайдын 2016 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 126 дугаар тушаалын хавсралт “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам”
14. 2017 оны 11 дүгээр сарын 30-ны 195 дугаар тушаалын хавсралт “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн журам”

15. УИХ-ын 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр баталсан “Зөрчлийн тухай хууль” /шинэчилсэн найруулга/. Энэ хуулийн 6.1-р зүйлд “Хог хаягдлын тухай хууль зөрчих тухай”
16. ЗГ-ын 2015 оны 288 дугаар тогтоолын хавсралт “Хог хаягдлын норматив тогтоох аргачлал”
17. БОАЖЯ-ны Сайдын 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/443 дугаар тушаалын хавсралт “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”
18. БОАЖЯ-ны Сайдын 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/445 дугаар тушаал “Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх”
19. БОАЖЯ-ны Сайдын 2017 оны 12 сарын 25-ны өдрийн А/368 дугаар тушаалын хавсралт “Энгийн хог хаягдлын норматив хэмжээг тогтоох аргачлал”
20. БОАЖЯ-ны Сайдын 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/445 дугаар тушаалын хавсралт “Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан заавар”
21. БОАЖЯ-ны Сайдын 2018 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн А/18 дугаар тушаал “Аюултай хог хаягдлыг цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага болон зөвшөөрөл олгох журам”
22. МУ-ын ЗГ-ын 2018 оны 317-р тогтоолоор батлагдсан “Барилга, байгууламжийг ашиглалтанд оруулах дүрэм”
23. КЧР ТББ-ын “Монгол Улсын барилгын салбарын нөөцийн үр ашигтай байдал, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих” төслийн хүрээнд 2017 онд боловсруулан гаргасан “Барилгын хог хаягдлын менежментийн суурь судалгаа”
24. КЧР ТББ-ын дээрх төслийн хүрээнд 2017 онд боловсруулан гаргасан “Монгол Улсад барилгын хог хаягдал дахин боловсруулах боломжийн судалгаа”
25. Зам тээвэр, барилга хот байгуулалтын яамны 2012 оны “Барилга байгууламжийг буулгах үйл ажиллагааны дүрэм” БД 20-101-12



Зургийг П. Сэргэлэн /ШУТИС, БАС-ийн Ахлах багш/

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Барилгын хог хаягдлын чиглэлээр өнөөгийн хууль, дүрэм, журам стандартуудад тусгагдсан зорилтууд тэдгээрийн хэрэгжилт

А. Хог хаягдлын тухай хуулинд (2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн шинэчилсэн найруулга)

4.1.37-д “Барилгын хог хаягдал” гэж барилгын суурь бэлтгэх, барилга барих, засварлах, буулгах болон авто зам барих, засварлахад үүсэх хог хаягдал, явган хүний зам талбай, ногоон байгууламжийн тохижилт, инженерийн шугам сүлжээ тавих, засварлах, солих үед үүсэх хог хаягдал болон барилгын материалын худалдаа, үйлдвэрлэлээс гарах хог хаягдлыг гэж тодорхойлсон.

8.2.1-д “Тээврийн хэрэгслийн болон барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмыг баталж хэрэгжилтэд хяналт тавих” гэж БХБЯ-ны үйл ажиллагааны чиглэлийг заасан.

8.2.3-д “Барилгын хог хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх” гэж үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон.

10.2.11-д “Барилга барих, буулгах, засварлах үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, булшлах эрх бүхий иргэн аж ахуйн нэгж байгууллагад шилжүүлж, үйлчилгээний хөлсийг хариуцах” гэсэн заалт орсноор хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааг тодорхойлсон.

10.2.12-д “Хог хаягдлын талаарх сургалтад хамрагдаж мэдлэгээ дээшлүүлэх” заалт орсноор сургалтын чиглэлийг гарсан.

Нийслэлийн нутаг дэвсгэрт барилгын болон инженерийн байгууламжийн ажил үйлчилгээнээс гарсан хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2012 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 94 дүгээр тогтоолоор “Барилгын хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хүргэх” журам батлагдсан хэдий ч тус журам мөрдөгдөөгүй.

Хэрэгжилтийн байдал:

7.1.1. “Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийг 2014 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн Засгийн газрын № 298 тоот тогтоолоор 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр баталсан.

I үе шатны хөтөлбөрт (2014 – 2017)

Хог хаягдлыг бууруулах эрх зүй, зохион байгуулалтын орчныг боловсронгуй болгож, менежментийг сайжруулах, дэд бүтцийн болон санхүүгийн чадавхыг бэхжүүлэх хог хаягдлыг бууруулах үйл ажиллагаанд иргэд, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, зөв дадал, хэвшлийг төлөвшүүлэхэд чиглэсэн цогц бодлого үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

II үе шатны хөтөлбөрт (2017– 2022)

Хог хаягдлаас үүдэлтэй орчны доройтлыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлж, ногоон хэрэглээний соёл, нийгмийн хариуцлагын ойлголтыг төлөвшүүлж, хог хаягдлын зохистой менежментийн тогтолцоо бий болж цэвэр эрүүл орчин бүрдүүлэх гэж тусгасан байна.

- Барилгын хог хаягдлын барилга хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх үүргийг тодорхой болгон хэрэгжүүлэх чиглэлүүдийг тодорхойлсон. Тус хуулийн 8.2.1-р заалтын хүрээнд: “Тээврийн хэрэгслийн болон барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах булшлах журам”-ыг баталж хэрэгжилтэнд хяналт тавих ажил 2019 онд хийгдэнэ.
- “Барилгын доторхи хог хаягдлын менежмент -Ашиглалтын дүрэм” (МУ-ын MNS BS 5906:2018) стандартыг боловсруулж батлан гаргасан.
- БХБЯ-ны барилга, байгууламжийн барилгын норм дүрэм, стандарт боловсруулах үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, сэргээн ашиглах, устгах булшлах болон дахин боловсруулах тухай журам” боловсруулахаар тусгагдсан байна.
- 2018-2019 онд БХТ-ийн Норм нормативын хэлтэс нь “Үйлдвэрийн газрын хортой хог хаягдлыг булшилж аюулгүй болгох бүс газар, төлөвлөлтийн шаардлага БНбаД” боловсруулж байна.
- 8.2.3 –р заалтын хүрээнд ажил хийгдээгүй.
- 10.2.12-р заалтын хүрээнд КЧР-ын “Монголын Улсын барилгын салбарын нөөцийн үр ашигтай байдал, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих” төслийн хүрээнд 2018-2020 оны хооронд барилгын салбарын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулсан барилгын хог хаягдлын менежментийн чиглэлээр чадавхижуулах сургалтыг зохион байгуулж байна.

“Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр”-т

4.1.5-р заалтын хүрээнд “Хог хаягдлын ангиллын систем, менежментийн тогтолцоонд Европын Холбооны стандартыг нэвтрүүлэх.”

4.2.1-р заалтын хүрээнд “Холбогдох яамд тухайн салбарын үйлдвэрлэл эрхлэлтээс гарах хатуу хог хаягдлыг хянах, байгаль орчинд халгүй арга технологиор зайлуулах менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх.”

4.5.2-р заалтын хүрээнд “Хог хаягдлыг дахин боловсруулах, эрчим хүч гаргах, бордоо, зам талбай, барилгын материал үйлдвэрлэх зэрэг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн бий болгох үйл ажиллагааг дэмжих.”

Хэрэгжилтийн байдал:

4.1.5-р заалтанд тусгагдсан “Хог хаягдлын систем, менежментийн тогтолцоонд Европын Холбооны стандартыг нэвтрүүлэх” чиглэл гарсан. Энэ нь Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.1.5–д заагдсан байна.

Барилгын тухай хуулинд (2016 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн шинэчилсэн найруулга):

Барилгын тухай хуулийн 40.1.14-р заалтын хүрээнд “Хог хаягдлын тухай хууль”-ийн 8.9-р заалтуудыг хэрэгжүүлэх. Үүнд:

8.2.1-р заалтын хүрээнд “Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ыг батлах хэрэгжилтэнд хяналт тавих.

8.2.3-р заалтын хүрээнд “Барилгын хог хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах устгах, булшлах үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх”

Барилга доторх хог хаягдлын менежмент– Ашиглалтын дүрэм MNS BS 5906 :2018

Энэхүү стандарт нь эрүүл мэндийн байгууллага, орон сууцны ба орон сууцны бус барилгаас ашиглалтын үед гарах хог хаягдлыг хадгалах, цуглуулах, дахин боловсруулах болон эргүүлж ашиглах зорилгоор ялгах, мөн эх үүсвэр дээр нь боловсруулах аргуудыг ашиглах дүрэм маягаар боловсруулагдан батлагдсан байна.

Зөвхөн орон сууцны барилга байгууламжийн болон бусад барилгын ашиглалтын үед гарах хог хаягдлын талаар голчлон заагдсан заалтууд бүхий ашиглалтын дүрэм гэсэн зориулалтаар боловсрогдсон учраас барилгын салбарт өргөн хүрээнд хэрэгжих боломж нь хязгаарлагдмал байдлаар хэрэгжиж болно.



Зургийг П. Сэргэлэн /ШУТИС, БАС-ийн Ахлах багш/

Барилгын хог хаягдлын менежмент болон барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйл ажиллагаатай холбогдсон хууль эрх зүйн орчныг бүрдүүлж буй хууль, стандарт дүрэм журмыг судалсны үндсэн дээр гаргасан дүгнэлт зөвлөмж

ДҮГНЭЛТ

1. Барилгын хог хаягдлын чиглэлээр тодорхой зорилт тусгагдсан доорх хууль, стандарт дүрмийн хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

- Барилгын тухай хуулийн /шинэчилсэн найруулсан/ 40.1.14–р заалт, Хог хаягдлын тухай хуулийн 8.2, 8.2.1–ын заалт
- Хог хаягдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2017 оны 5 дугаар сарын 12-ноос /энэ хуулинд барилгын хог хаягдал, ангилах, цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах талаар тусгасан 8.2-р заалтууд/
- УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоолоор “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т болон МУ-ын ЗГ-ын 2016 оны 121 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан. ISO, Евро стандартуудыг барилга, барилгын материалын салбарт үндэсний стандарт болгон нутагшуулах.
- Европын Холбооны нийтлэг зарчим, хэм хэмжээ, стандартыг судлан нэвтрүүлэх тухай ЗГ-ын 2011 оны 89 дүгээр тогтоол.
- МУ-д мөрдөж буй стандартын бодлого, хэрэгжилтийг боловсронгуй болгох, олон улс болон Европын стандартын түвшинд нийцүүлэх тухай ЗГ-ын 2010 оны 38 дугаар тогтоол.
- 2017 онд Хог хаягдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ батлагдан энэ хуулийн барилгын хог хаягдал, ангилах, цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах талаар тусгасан заалтуудыг хэрэгжүүлэхтэй уялдан 2018 онд “Барилга доторх хог хаягдлын менежмент-Ашиглалтын дүрэм, үндэсний MNS BS 5906:2018 стандарт”-ыг гаргасан.
- Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөрийн 2 дугаар үе шатыг хэрэгжүүлэх.

2. Барилгын хог хаягдлын чиглэлийн хууль, стандарт, дүрэм журмын хэрэгжилт хангалтгүй байгаагийн шалтгаан

1. Хог хаягдлын тухай хууль, барилгын доторх хог хаягдлын менежмент стандарт дүрэм журмуудын хоорондын уялдаа зохицуулалт хангалтгүй.

2. “Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх “Барилгын хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөр” боловсруулж хэрэгжүүлээгүй.
3. Барилгын хог хаягдлыг менежментийн чиглэлийн стандартууд, дүрэм журмуудыг олон улсын (ISO) болон (EN)-ны стандартуудад нийцүүлэн мөрдөх үйл ажиллагаа ажил маш удаашралтай байна.
4. Хог хаягдлын хуулийн заалтын дагуу холбогдох журмууд боловсруулагдаагүй. Тус хуулийн тухайлбал:

8.1.5-р заалтын дагуу 8.1.4 –т заасан Барилга буулгах, хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах үйл ажиллагааг эрхэлдэг мэргэшсэн аж ахуйн нэгжүүд байхгүй.

8.1.9–р заалтын дагуу барилгын хог хаягдлын менежментийг эрхлэгч байгууллагуудыг бүртгэх.

Хог хаягдлын тухай хуулийн 8-2-р заалтын дагуу 8.2.1-р заалтыг хэрэгжүүлж барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам боловсруулж, баталж гаргаагүй.

5. Барилгын хог хаягдлын нэр томьёо, тодорхойлолтын тухай үндэсний стандарт боловсруулагдаж гараагүй .

ЦААШДЫН ЗОРИЛТ, ЗӨВЛӨМЖ

1. Монгол Улсын “Хог хаягдлын тухай” хуулийн дагуу “Барилгын хог хаягдлын нэр томьёо, тодорхойлолт” стандартыг боловсруулах, олон улсын (ISO) болон бүс нутаг (EN)-ийн хог хаягдлын стандартуудыг үндэсний болгон орчуулж хэрэглэх шаардлагатай .
2. Барилгын хог хаягдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, иргэнийг стандартчилсан норматив, техникийн баримт бичгээр хангаж, дэмжиж ажиллах шаардлагатай байна.
3. МУ-ын ЗГ-ын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах” дүрмийн 2.4 дэх хэсэгт заасан бичиг баримтын бүрдэлд барилгын хог хаягдлыг хэрхэн зайлуулсан талаарх акт, баримтыг шаардаж байхаар тусгаж, комисс ажиллуулж байвал хэрэгжилтийг бүрэн хянах боломжийг бүрдүүлэх шаардлагатай.

4. Нийслэлийн нутаг дэвсгэрт барилгын болон инженерийн байгууламжийн ажил үйлчилгээнээс гарсан хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2012 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 94 дүгээр тогтоолоор баталсан “Барилгын хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хүргэх журам”-ыг мөрдүүлэх.
5. Барилга буулгах буюу хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг аж ахуйн нэгж байгууллага иргэнд олгох журмыг боловсруулж мөрдөх
6. 8.1.9–р заалтын дагуу барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах үйл ажиллагааг эрхлэгч байгууллагуудыг бүртгэх.
7. Хог хаягдлын тухай хуулийн 8.2-р заалтын дагуу Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам боловсруулах.
8. Хүн ам өсөх, барилга байгууламж ихээр барих, хуучин барилга буулгах, гэр хорооллыг дахин төлөвлөхөд гарах хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, сэргээн ашиглах, устгах булшлах болон дахин боловсруулах асуудлыг стандартчилахын тулд Барилгын хог хаягдлын стандарт-тай болох шаардлагатай байна.
9. 2019-2020 онд Хог хаягдлын дараах стандартуудыг орчуулж боловсруулж гаргах шаардлагатай байна.



Зургийг П. Сэргэлэн /ШУТИС, БАС-ийн Ахлах багш/

Хүснэгт 5.1

№	Стандартын дугаар	Стандартын нэр	Боловсруулах хугацаа	Хуудас тоо
1	ГОСТ Р 57678-2017	Барилгын хог хаягдлын нэр томъёо, тодорхойлолт–ын стандарт. Барилгын хог хаягдлын тухай стандарт	2019-2020	24x
2	EN 13071:2008	Selective waste collection containers - Above-ground mechanically-lifted containers with capacity from 80 l to 5 000 l for selective collection of waste	2019-2020	24x
3	BS EN 274-1:2002	Waste fittings for sanitary appliances - Part 1: Requirements	2019-2020	22x
4	EN 840-1:2012	Mobile waste containers - Part 1: Containers with two wheels with a capacity from 80 l to 390l for comb lifting devices - Dimensions and design.	2019-2020	22x
5	BS 1703	Specification for refuse chutes and hoppers	2019-2020	16x

Хавсралт 1

ГОСТ Р 57678-2017 Ресурсосбережение. Обращение с отходами. Ликвидация строительных отходов - Resources saving. Waste treatment. Management of construction waste

Энэхүү стандартыг орчуулж Монгол Улсад мөрдөх Барилгын хог хаягдлын MNS нэгдсэн стандарт болгон нутагшуулах, нэвтрүүлэх ОХУ-ын ГОСТ Р57678-2017 стандартын дагуу гарсан дагалдах барилгын норм, дүрэм, журмуудыг жишиг болгон боловсруулж хэрэгжүүлэх.

Хавсралт 2

Судалгаа хийж дүгнэлт зөвлөмж гаргахад ашигласан эх сурвалж:

1. Барилгын тухай хууль /шинэчилсэн найруулга/ (2016 оны 2 дугаар сарын 05)
2. Хог хаягдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ (2017 оны 5 дугаар сарын 12)
3. Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр (2014 оны 9 дүгээр 18-ны МУ-ын ЗГ-ын 298 дугаар тогтоол)
4. Барилгын доторх хог хаягдлын менежмент - Ашиглалтын дүрэм MNS BS 5906:2018
5. МУ-ын ЗГ-ын Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох талаар авах арга хэмжээний тухай 2001 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 256 дугаар тогтоол
6. МУ-ын ЗГ-ын Хог ааягдлыг бууруулах тухай хөтөлбөр (1999 оны 3 дугаар сарын 24-ний 50 дугаар тогтоол)
7. Хот байгуулалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/ (2008 оны 5 дугаар сар)
8. Стандартчилал, техникийн зориулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ (2018 оны 07 дугаар сар)
9. МУ-ын ЗГ-ын 2016 оны 121 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”
10. МУ-ын ЗГ-ын 2009 оны 157 дугаар тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлтийн гамшгийн эрсдлийг бууруулах үндэсний хөтөлбөр”
11. УИХ-ын 2016 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай”
12. МУ-ын ЗГ-ын 2016 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан “Ногоон хөгжлийн үзэл баримтлал, ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”
13. “Барилгын хог хаягдлын менежментийн суурь судалгаа”, КЧР ТББ, 2017 он
14. “Монгол Улсад барилгын хог хаягдлыг дахин боловсруулах боломжийн судалгаа”, КЧР ТББ, 2017 он



